



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/174/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123
Аудитор: Б.Мөнхбамбар
Утас: 70512127

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

᠑᠐᠒᠒.᠐3.᠒᠒ № 144
танай _____-ны № _____-г

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА
П.АМАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь "Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай" хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, 5279 даатгуулагчид 1,342.5 сая төгрөгийг буцаан олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 зорилт, 73 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 90.6 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9940607259.20</u>	<u>8293839019.30</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5797638970.55	4847416853.90
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	5792598970.55	4847416853.90
3121	Төгрөг	5792598970.55	4847416853.90
31211	Төрийн сангийн харилцах	398986.41	320079.16
31213	Арилжааны банк дахь харилцах	5792199984.14	4846967788.74
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах		128986.00
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	5040000.00	
33	АВЛАГА	4127505997.61	3430836396.67
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	344093185.51	470948135.93
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3769808666.47	2938692767.48
335	Бусад авлага	13604145.63	21195493.26
3351	Байгууллагаас авах авлага	13604145.63	21195493.26
35	БАРАА МАТЕРИАЛ	15462291.04	15585768.73
354	Хангамжийн материал	15462291.04	15585768.73
35410	Бичиг хэргийн материал	3594390.00	2865549.00
35420	Аж ахуйн материал	10572244.10	11232718.10
35430	Сэлбэг хэрэгсэл		251200.00
35440	Түлш, шатах тослох материал	0.11	400.00
35450	Барилгын засварын материал		27850.00
35470	Бусад хангамжийн материал	1295656.83	1208051.63
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>507339798.43</u>	<u>547180831.44</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	507339798.43	547180831.44
392	Биет хөрөнгө	490011798.43	529852831.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	454927816.14	454927816.14
39202	Хуримтлагдсан элэгдэл	34797032.14	46396042.90
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69900000.00	10485000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	69876900.00	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	69030966.18	121400789.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	26377861.21	30154882.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	74889900.00	71826900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	49488413.41	53790070.92
39214	Бусад үндсэн хөрөнгө	5000000.00	5000000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	3196677.13	3446677.09
393	Биет бус хөрөнгө	17328000.00	17328000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	17328000.00	17328000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>10447947057.63</u>	<u>8841019850.74</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>168414499.35</u>	<u>156425280.43</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	168414499.35	156425280.43
413	Өглөг	19167922.86	24473428.20

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	19094669.36	24401777.46
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	1602.76	
4136	Бусад өглөг	71650.74	71650.74
41361	Байгууллагад төлөх өглөг	71650.74	71650.74
414	Урьдчилж орсон орлого	149246576.49	131951852.23
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	149246576.49	131951852.23
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10279532558.28	8684594570.31
51	Засгийн газрын хувь оролцоо	10279532558.28	8684594570.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	304205531.58	304205531.58
51101	Өмч: - төрийн	304205531.58	304205531.58
512	Хуримтлагдсан үр дүн	9893597128.44	8298659140.47
51210	Өмнөх үеийн үр дүн	7496828113.92	9886052051.30
51220	Тайлант үеийн үр дүн	2396769014.52	-1587392910.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	81729898.26	81729898.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10447947057.63	8841019850.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	51891788885.68	67167830272.69
11	ТАТВАРЫН ОРЛОГО	25532014443.69	25903117687.99
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	25532014443.69	25903117687.99
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	18461998177.19	17784027068.90
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1635278880.97	1854739483.47
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1208343544.09	1381407606.23
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	304598154.82	348062160.67
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	3921795686.62	4534881368.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62451870.99	71100749.70
120	Нийтлэг татварын бус орлого	62451870.99	71100749.70
120002	Хүүгийн орлого	8322375.19	31528.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30528540.80	31521174.69
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12080703.00	19537624.69
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	521100.00	49000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17926737.80	11934550.00
120009	Бусад орлого	23600955.00	39548047.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26297322571.00	41193611835.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	8338721401.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		8338721401.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6437500.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6152500.00	

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285000.00	
1330	Төсвийн захирагчдаас	25738977171.00	32231122634.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	25738977171.00	32231122634.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	551907900.00	623767800.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	551907900.00	617008800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		6759000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	49495019871.16	68755223183.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49495019871.16	68755223183.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	582086863.72	588760573.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	401257683.51	425339361.49
210101	Үндсэн цалин	319670926.51	309933309.76
210102	Нэмэгдэл	61810757.00	74735359.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14376000.00	22001995.19
210104	Урамшуулал	5400000.00	18668696.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51832813.02	52979334.23
210201	Тэтгэврийн даатгал	35863123.33	37063518.47
210202	Тэтгэмжийн даатгал	3991126.60	4360411.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	3192901.28	3406008.99
210204	Ажилгүйдлийн даатгал	798225.32	731145.92
210205	Эрүүл мэндийн даатгал	7987436.49	7418249.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37420758.45	37905046.50
210301	Гэрэл, цахилгаан	2318381.35	2325414.50
210302	Түлш, халаалт	33001617.10	32917500.00
210303	Цэвэр, бохир ус	2100760.00	2662132.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17690139.40	16001027.39
210401	Бичиг хэрэг	2046812.00	3121056.00
210402	Тээвэр, шатахуун	7780499.89	6885600.11
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4337951.51	4099886.28
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	189999.00	180000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3334877.00	1714485.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5652127.28	1679050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1499977.28	784050.00
210604	Урсгал засвар	4152150.00	895000.00
2107	Томиллолт, зочны зардал	2432000.00	2369300.00
210702	Дотоод албан томиллолт	2432000.00	2369300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27010296.69	13638597.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17685003.74	4343600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1250000.00

210803	Даатгалын үйлчилгээ	1044867.00	1044867.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25080.00	84480.00
210807	Газрын төлбөр	103968.00	103968.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4964430.00	4967483.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3186947.95	1844199.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38791045.37	38848856.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2285000.00	1900000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36506045.37	36948856.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48912933007.44	68166462609.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	43778312590.00	59185396553.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	43765295707.00	59127620273.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12130183.00	5398180.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	886700.00	51808100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		570000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5134620417.44	8981066056.72
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5134620417.44	8981066056.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2396769014.52</u>	<u>-1587392910.83</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>2396769014.52</u>	<u>-1587392910.83</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>51122248382.06</u>	<u>67824374161.66</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	<u>24706313743.39</u>	<u>25780464502.71</u>
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	24706313743.39	25780464502.71
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	18132986104.48	17701779067.56
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1425008395.74	1845718229.65
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	969054553.98	1373922269.48
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	266626701.42	347658821.38
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	3912637987.77	4511386114.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>74129838.67</u>	<u>81393708.95</u>
120	Нийтлэг татварын бус орлого	74129838.67	81393708.95
120002	Хүүгийн орлого	8322375.19	31528.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65807463.48	81362180.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65286363.48	81313180.20
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	521100.00	49000.00
120009	Бусад орлого		0.74

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26341804800.00	41962515950.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	48070700.00	9169837300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	48070700.00	9169837300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6437500.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6152500.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285000.00	
1330	Төсвийн захирагчдаас	25735388700.00	32168910850.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	25735388700.00	32168910850.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	551907900.00	623767800.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	551907900.00	617008800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		6759000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	49567069085.94	68774596278.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49567069085.94	68774596278.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	544063997.60	554578750.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	400181013.52	425339361.49
210101	Үндсэн цалин	296269628.52	309933309.76
210102	Нэмэгдэл	84179385.00	74735359.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14332000.00	22001995.19
210104	Урамшуулал	5400000.00	18668696.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52909815.10	52979334.23
210201	Тэтгэврийн даатгал	36608301.07	37063518.47
210202	Тэтгэмжийн даатгал	4074055.76	4360411.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	3259244.61	3406008.99
210204	Ажилгүйдлийн даатгал	814811.15	731145.92
210205	Эрүүл мэндийн даатгал	8153402.51	7418249.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37420758.45	37905046.50
210301	Гэрэл, цахилгаан	2318381.35	2325414.50
210302	Түлш, халаалт	33001617.10	32917500.00
210303	Цэвэр, бохир ус	2100760.00	2662132.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19359934.51	15933060.28
210401	Бичиг хэрэг	4553057.00	2392215.00
210402	Тээвэр, шатахуун	7780500.00	6886000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4337951.51	4099886.28
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	189999.00	180000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2498427.00	2374959.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5652127.28	6358250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1499977.28	5435400.00
210604	Урсгал засвар	4152150.00	922850.00
2107	Томилолт, зочны зардал	2432000.00	2369300.00

210702	Дотоод албан томилолт	2432000.00	2369300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23823348.74	11794398.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17685003.74	4343600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1250000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1044867.00	1044867.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25080.00	84480.00
210807	Газрын төлбөр	103968.00	103968.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4964430.00	4967483.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2285000.00	1900000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2285000.00	1900000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49023005088.34	68220017527.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	43889687054.84	59238951471.09
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	43840006292.27	59123248643.41
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12130183.00	5698180.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36663879.57	57926547.68
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	886700.00	51808100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		270000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5133318033.50	8981066056.72
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5133318033.50	8981066056.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1555179296.12	-950222116.65
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1555179296.12	-950222116.65
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4242459674.43	5797638970.55
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5797638970.55	4847416853.90

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	304,205,531.58	81,729,898.26	7,497,039,258.93		7,882,974,688.77
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-211,145.00		-211,145.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	304,205,531.58	81,729,898.26	7,496,828,113.93	0.00	7,882,763,543.77
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			-0.01		-0.01
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайланг үеийн үр дүн			2,396,769,014.52		2,396,769,014.52
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	304,205,531.58	81,729,898.26	9,893,597,128.44	0.00	10,279,532,558.28
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	304,205,531.58	81,729,898.26	12,290,366,142.95	0.00	12,676,301,572.79
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-7,545,077.14		-7,545,077.14
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	304,205,531.58	81,729,898.26	9,886,052,051.30	0.00	10,271,987,481.14
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайланг үеийн үр дүн			-1,587,392,910.83		-1,587,392,910.83
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	304,205,531.58	81,729,898.26	8,298,659,140.47	0.00	8,684,594,570.31

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60020925900.00	59735333673.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60020925900.00	59735333673.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	569927800.00	554578750.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	432182700.00	425339361.49
210101	Үндсэн цалин	312932900.00	309933309.76
210102	Нэмэгдэл	76360000.00	74735359.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23676400.00	22001995.19
210104	Урамшуулал	19213400.00	18668696.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54178900.00	52979334.23
210201	Тэтгэврийн даатгал	36887300.00	37063518.47
210202	Тэтгэмжийн даатгал	4322900.00	4360411.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	3458300.00	3406008.99
210204	Ажилгүйдлийн даатгал	864700.00	731145.92
210205	Эрүүл мэндийн даатгал	8645700.00	7418249.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38189700.00	37905046.50
210301	Гэрэл, цахилгаан	2514700.00	2325414.50
210302	Түлш, халаалт	32918000.00	32917500.00
210303	Цэвэр, бохир ус	2757000.00	2662132.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16321400.00	15933060.28
210401	Бичиг хэрэг	2392300.00	2392215.00
210402	Тээвэр, шатахуун	7264000.00	6886000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4100100.00	4099886.28

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	190000.00	180000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2375000.00	2374959.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10745400.00	6358250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5435400.00	5435400.00
210604	Урсгал засвар	5310000.00	922850.00
2107	Томилолт, зочны зардал	2489000.00	2369300.00
210702	Дотоод албан томилолт	2489000.00	2369300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13920700.00	11794398.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4642600.00	4343600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2000000.00	1250000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1050000.00	1044867.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150000.00	84480.00
210807	Газрын төлбөр	250000.00	103968.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5828100.00	4967483.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1900000.00	1900000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1900000.00	1900000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59450998100.00	59180754923.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	59450998100.00	59180754923.41
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	59391704000.00	59123248643.41
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7486000.00	5698180.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51808100.00	51808100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	60020925900.00	30502413830.29
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9169837300.00	9169837300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	9169837300.00	9169837300.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	50851088600.00	21275868916.08
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	50844329600.00	21269109916.08
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6759000.00	6759000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	56707614.21
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		56658614.21
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		49000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5797638970.55
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4857416853.90
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	71.00	71.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35.00	35.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00

620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	35.0	35.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	30.00	30.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	5.00	5.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын сан “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ.” гэсэн зорилгын хүрээнд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах, нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,606,927.2 мянган төгрөгөөр буюу 15.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,797,639.0	4,847,416.9	-950,222.1
Авлага	4,127,506.0	3,430,836.4	-696,669.6
Бараа материал	15,462.3	15,585.8	123.5
Үндсэн хөрөнгө	507,339.8	547,180.8	39,841.0
Нийт хөрөнгө	10,447,947.1	8,841,019.9	-1,606,927.2
Өр төлбөр	168,414.5	156,425.3	-11,989.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	10,279,532.6	8,684,594.6	-1,594,938.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,447,947.1	8,841,019.9	-1,606,927.2

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 950,222.1 мянган төгрөгөөр буурсан нь НДЕГ-ын даргын 2019 оны А/121 тоот тушаалд заасны дагуу “сарын бүрийн эцэст нийгмийн даатгалын санд дараа сарын зарлагын 100 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нөөцтэй байхаар зохицуулах” гэж заасан нь нөлөөлсөн байна.
- Авлагын данс 696,669.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулсан нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө данс 547,180.8 мянган төгрөг болж 39,841.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үнэ төлбөргүй хүлээн авсан 64,855.3 мянга, шилжүүлэн авсан 11,934.5 мянга нийт 76,789.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нөлөөлсөн байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 156,425.3 мянган төгрөг болж 11,989.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны өр төлбөр барагдсан нь нөлөөлсөн байна.
- Засгийн газрын хувь оролцоо данс 1,594,938.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 46,501,686.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 46,501,686.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 13,519,239.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 60,020,925.9 мянган төгрөгөөр баталсан нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 63 дугаар тогтоолын дагуу тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлж олгосон нөлөөлсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 60,020,925.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 9,169,837.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 6,759.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 50,844,329.6 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 9,169,837.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 49.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 6,759.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 50,558,688.4 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангаас орлого бүрдүүлж, нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардалд 59,127,951.2 мянган төгрөг, үйл ажиллагааны зардалд 607,382.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 59,735,333.7 төгрөг буюу 99.5 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Нийгмийн даатгалын сан					
1	Тэтгэврийн даатгалын сангийн	56,247,987.4	56,182,109.5	65,877.9	100%
2	Тэтгэмжийн даатгалын сангийн	2,139,291.4	2,027,587.1	111,704.3	95%
3	ҮОМШӨ-ний даатгалын сангийн	173,672.0	150,950.9	22,721.1	87%
4	Ажилгүйдлийн даатгалын сангийн	836,207.3	767,303.8	68,903.5	92%
Дүн		59,397,158.1	59,127,951.3	269,206.8	
Үйл ажиллагааны зардал					
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	544,361.1	530,760.0	13,601.1	98%
2	80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	5,670.0	5,577.6	92.4	98%
3	80205-Мэдээлэл, сурталчилгааны зардал	2,700.0	2,700.0	0.0	100%
4	80213-Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс	400.0	101.0	299.0	25%
5	80224-Зөвлөл хороо, комиссын гишүүд ажлын хөлс	11,342.6	10,737.5	605.1	95%
6	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж	51,808.1	51,808.1	0.0	100%
7	80813- Хуульд заасан үндэслэлээр алба	2,300.0	1,848.7	451.3	80%
8	80820-Бусад тусламж дэмжлэг	5,186.0	3,849.5	1,336.5	74%
Дүн		623,767.8	607,382.4	16,385.4	
Нийт дүн		60,020,925.9	59,735,333.7	285,592.2	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхбамбар, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн №1/57 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 49,495,019.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 989,900.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд байр ашиглалттай холбоотой зардал 484.3 мянга, бичиг хэргийн зардал 940.7 мянга, нийт 1,425.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Тээвэр шатахуун, бичиг хэргийн зардал: Шатах тослох материал, бичиг хэргийн материалын үнэ өмнөх оноос дунжаар 52.0 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гаргасан тушаал шийдвэр, орлого зарлагын мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын санд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	-	-	-	-	-
Зөвлөмж	2	-	2	-	100
Нийт дүн	2	-	2	-	100